



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: baterdene@audit.gov.mn
Ахлах Аудитор: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114, Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ньюбаланс Аудит ХХК-ийн
Захирал: Б.Лхагвадорж Утас: 99101901
Цахим хаяг : newbalance.lhaqvaa@gmail.com
Чанарын хяналтын менежер: Д.Гэрэлчулуун
Цахим хаяг : d.gerlee98@gmail.com
Аудиторын туслах: Д.Балжинням
Цахим хаяг : d.baljii73@gmail.com
Утас: 86267997

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт	20
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар


**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Т.ЭНХБАЯР
ТАНАА

2022.02.25 № 01/213
танай _____-ны № _____-Т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>202,030,384.22</u>	<u>233,614,269.55</u>
33	АВЛАГА	17,970,960.00	4,400,000.00
335	Бусад авлага	17,970,960.00	4,400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	8,470,960.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,500,000.00	4,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	184,059,424.22	229,214,269.55
351	Түүхий эд материал	2,926,000.00	3,429,600.00
35130	Эм боох материал	2,926,000.00	3,429,600.00
354	Хангамжийн материал	180,678,424.22	225,784,669.55
35410	Бичиг хэргийн материал	2,591,750.00	4,326,450.00
35420	Аж ахуйн материал	5,911,659.81	15,628,109.81
35440	Түлш, шатах тослох материал	4,125,000.46	5,128,476.46
35450	Барилгын засварын материал	6,462,407.86	11,040,807.86
35460	Хүнсний материал	36,299,830.00	46,391,831.80
35470	Бусад хангамжийн материал	125,287,776.09	143,268,993.62
35600	Мал амьтад	455,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,589,712,099.16</u>	<u>2,632,603,843.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,589,712,099.16	2,632,603,843.92
392	Биет хөрөнгө	2,520,629,666.64	2,565,136,723.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,601,051,032.00	2,671,344,544.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-248,525,403.75	-367,251,745.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,500,000.00	-2,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	285,459,104.40	376,273,350.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-207,687,831.14	-225,345,959.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,835,403.20	136,133,038.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-68,580,712.59	-78,486,371.11
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,973,359.00	4,973,359.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,917,484.00	-4,917,484.00
39217	Ном	47,022,199.52	52,413,991.64
393	Биет бус хөрөнгө	69,082,432.52	67,467,120.71
39301	Програм хангамж	11,555,745.00	11,555,745.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,057,312.48	-3,672,624.29
39303	Бусад биет бус хөрөнгө	59,584,000.00	59,584,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,791,742,483.38</u>	<u>2,866,218,113.47</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,791,742,483.38</u>	<u>2,866,218,113.47</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,791,742,483.38	2,866,218,113.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,231,441,861.00	1,231,441,861.00
51101	Өмч: - төрийн	1,231,441,861.00	1,231,441,861.00

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	241,771,477.93	316,311,608.02
51210	Өмнөх үеийн үр дүн	241,771,477.93	241,835,977.93
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	74,475,630.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,318,529,144.45	1,318,464,644.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,791,742,483.38	2,866,218,113.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,926,732,872.51	1,965,882,000.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,461,012.51	1,670,190,299.00
120	Нийтлэг татварын бус орлого	67,461,012.51	122,085,099.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,461,012.51	122,085,099.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	67,461,012.51	122,085,099.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	1,548,105,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	1,548,105,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,950,460.00	295,691,701.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,594,321,400.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,470,960.00	25,796,201.91
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,970,960.00	21,606,601.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,189,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	256,479,500.00	269,895,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	256,479,500.00	269,895,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,913,177,082.26	1,891,313,118.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,913,177,082.26	1,891,313,118.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,786,745,581.26	1,824,609,000.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,142,546,261.00	1,174,551,680.00
210101	Үндсэн цалин	1,142,546,261.00	1,174,551,680.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,740,431.22	157,462,574.32
210201	Тэтгэврийн даатгал	127,603,937.22	110,242,864.32
210202	Тэтгэмжийн даатгал	9,784,122.00	11,804,929.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,827,299.00	9,443,942.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,956,826.00	2,360,984.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,568,247.00	23,609,855.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,428,616.13	231,836,152.00

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	9,717,681.00	10,536,216.00
210302	Түлш, халаалт	205,210,935.13	220,579,936.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	720,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,238,320.00	46,593,343.16
210401	Бичиг хэрэг	2,986,360.00	5,627,440.91
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	11,242,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	730,600.00	1,448,700.00
210404	Ном, хэвлэл	00.00	14,129,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,028,450.00	2,592,551.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,492,910.00	9,642,250.00
210408	Бараа материал акалсны зардал	00.00	1,909,681.25
2105	Нормативт зардал	48,482,550.00	48,247,298.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,944,800.00	3,288,000.00
210502	Хоол, хүнс	45,537,750.00	44,959,298.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,830,943.58	5,407,700.00
210604	Урсгал засвар	17,830,943.58	5,407,700.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,423,100.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,423,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,000.00	3,061,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,000.00	3,061,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,488,459.33	156,025,652.84
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,924,300.00	4,462,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	156,564,159.33	151,563,502.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,431,501.00	66,704,117.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,839,800.00	61,823,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,818,800.00	54,663,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,021,000.00	7,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,978,622.00	4,876,245.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,978,622.00	4,876,245.68
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,613,079.00	4,572.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,613,079.00	4,572.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,555,790.25	74,568,882.71
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	93,252.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	93,252.62
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-93,252.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,555,790.25	74,475,630.09

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,231,441,861.00	1,318,529,144.45	241,771,477.93	2,791,742,483.38
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,231,441,861.00	1,318,529,144.45	241,771,477.93	2,791,742,483.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	64,500.00	64,500.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,231,441,861.00	1,318,529,144.45	241,835,977.93	2,791,806,983.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-64,500.00	00.00	-64,500.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	74,475,630.09	74,475,630.09
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,231,441,861.00	1,318,464,644.45	316,311,608.02	2,866,218,113.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,859,271,860.00	1,843,796,901.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,548,105,200.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	1,548,105,200.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	1,548,105,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,859,271,860.00	295,691,701.91
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,594,321,400.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,470,960.00	25,796,201.91

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,970,960.00	21,606,601.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,189,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	256,479,500.00	269,895,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	256,479,500.00	269,895,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,828,136,587.00	1,754,924,301.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,828,136,587.00	1,754,924,301.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,693,234,126.00	1,691,720,184.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,152,528,900.00	1,173,836,198.00
210101	Үндсэн цалин	907,654,435.00	774,791,404.00
210102	Нэмэгдэл	152,043,865.00	334,336,274.00
210104	Урамшуулал	92,830,600.00	63,547,730.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,160,790.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,591,400.00	158,178,056.32
210201	Тэтгэврийн даатгал	109,490,300.00	111,264,423.08
210202	Тэтгэмжийн даатгал	11,525,300.00	11,728,258.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,220,100.00	9,382,506.07
210204	Ажилгүйдлийн даатгал	2,305,100.00	2,345,850.24
210205	Эрүүл мэндийн даатгал	23,050,600.00	23,457,018.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,355,121.00	237,082,428.00
210301	Гэрэл, цахилгаан	9,717,681.00	13,999,016.00
210302	Түлш, халаалт	203,137,440.00	221,583,412.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,445,850.00	40,596,301.91
210401	Бичиг хэрэг	1,327,700.00	1,519,390.91
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	7,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	741,700.00	1,448,700.00
210404	Ном, хэвлэл	48,000.00	9,158,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,028,450.00	5,861,051.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,300,000.00	15,608,200.00
2105	Нормативт зардал	106,668,780.00	56,613,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,627,000.00	3,523,100.00
210502	Хоол, хүнс	74,931,580.00	49,472,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,110,200.00	3,618,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,192,675.00	10,010,100.00

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,192,675.00	5,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	4,810,100.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	1,423,100.00
210702	Дотоод албан томилолт	00.00	1,423,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,000.00	3,655,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,000.00	3,055,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,461,400.00	10,324,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,461,400.00	10,324,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,902,461.00	63,204,117.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,839,800.00	58,323,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,818,800.00	54,663,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,021,000.00	3,660,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	74,449,582.00	4,876,245.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	74,449,582.00	4,876,245.68
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,613,079.00	4,572.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,613,079.00	4,572.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,135,273.00	88,872,600.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,135,273.00	88,872,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,135,273.00	88,872,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	31,135,273.00	88,872,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,135,273.00	88,872,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-31,135,273.00	-88,872,600.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
----	---	-------	-------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,817,997,728.00	1,813,121,482.32	4,876,245.68	99.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,817,997,728.00	1,813,121,482.32	4,876,245.68	99.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,758,934,828.00	1,758,398,182.32	536,645.68	99.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,174,053,600.00	1,173,836,198.00	217,402.00	99.98
210101	Үндсэн цалин	779,932,800.00	774,791,404.00	5,141,396.00	99.34
210102	Нэмэгдэл	327,920,800.00	334,336,274.00	-6,415,474.00	101.96
210104	Урамшуулал	66,200,000.00	63,547,730.00	2,652,270.00	95.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,497,300.00	158,178,056.32	319,243.68	99.80
210201	Тэтгэврийн даатгал	111,535,100.00	111,264,423.08	270,676.92	99.76
210202	Тэтгэмжийн даатгал	11,740,600.00	11,728,258.31	12,341.69	99.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,392,400.00	9,382,506.07	9,893.93	99.89
210204	Ажилгүйдлийн даатгал	2,348,200.00	2,345,850.24	2,349.76	99.90
210205	Эрүүл мэндийн даатгал	23,481,000.00	23,457,018.62	23,981.38	99.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,082,428.00	237,082,428.00	00.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	14,000,000.00	13,999,016.00	984.00	99.99
210302	Түлш, халаалт	221,582,428.00	221,583,412.00	-984.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,792,300.00	29,792,300.00	00.00	100.00
210401	Бичиг хэрэг	948,700.00	948,700.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	7,000,000.00	7,000,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,448,700.00	1,448,700.00	00.00	100.00
210404	Ном, хэвлэл	790,600.00	790,600.00	00.00	100.00

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,996,100.00	3,996,100.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,608,200.00	15,608,200.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	56,613,600.00	56,613,600.00	00.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,523,100.00	3,523,100.00	00.00	100.0
210502	Хоол, хүнс	49,472,300.00	49,472,300.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,618,200.00	3,618,200.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,992,100.00	87,992,100.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,022,000.00	47,022,000.00	00.00	100.0
210602	Тавилга	8,160,000.00	8,160,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	32,810,100.00	32,810,100.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,423,100.00	1,423,100.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,423,100.00	1,423,100.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,155,500.00	3,155,500.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,555,500.00	2,555,500.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10324900.00	10324900.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,324,900.00	10,324,900.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59062900.00	54,563,300.00	4,499,600.00	92.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,062,900.00	54,563,300.00	4,499,600.00	92.38
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,002,900.00	54,563,300.00	4,439,600.00	92.48
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.00	60,000.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,548,105,200.00	1,548,105,200.00	4,876,245.68	100.0
14	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,548,105,200.00	1,548,105,200.00	4,876,245.68	100.0
145005	Тусгай шилжүүлгийн санхүүжилт	1,548,105,200.00	1,543,228,954.32	4,876,245.68	99.69
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	95.00	95.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	60.00	60.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		25,794,601.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ		25,794,601.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		22,194,601.91
2104	Хангамж, бараа материалын зардал		11,594,601.91
210401	Бичиг хэрэг		570,690.91
210404	Ном, хэвлэл		9,158,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,864,951.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	3600000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		3,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	25,796,201.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		25,796,201.91
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		21,606,601.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,189,600.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-

ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээд Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуультай холбоотойгоор 4 залруулга хийлгэж, 1 зөвлөмжийг өгсөн болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторовн туслах Д.Балжинням нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д.Гэрэлчулуун, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43-р тогтоол, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлан нийт зардлын 1,913.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 38.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74.5 сая төгрөгөөр буюу 2.67 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн дүн өсөхөд нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	17.9	4.4	-13.5
БАРАА МАТЕРИАЛ	184.1	229.2	45.1
Биет хөрөнгө	2,520.6	2,565.1	44.5
Биет бус хөрөнгө	69.1	67.5	-1.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,791.7	2,866.2	74.5
Хуримтлагдсан үр дүн	241.8	316.3	74.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,791.7	2,866.2	74.5

/сая. төгрөг/

Бараа материалын дансны үлдэгдэл 229.2 сая төгрөг болж 45.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд урсгал засварын материал, хоолны материал зэрэг бараа авч зарцуулсан нь бараа материал дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,632.6 сая төгрөг болж 42.9 сая төгрөгөөр өссөн нь Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 42.3 сая төгрөгийн дотуур байрны засвар хийгдсэн бөгөөд энэхүү засварын эх үүсвэр нь 2020 оны тайлан балансад тусгагдаж 2021 онд сайжруулалтаар нэмэгдсэн байна. Машин тоног төхөөрөмж дансанд 41.9 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл, гал тогооны тоног төхөөрөмж, Тавилга эд хогшилд 8.9 сая төгрөгийн хөрөнгө багш хөгжлийн төвийн тохижилтонд, номын фондод 4.3 сая төгрөгийн ном, Төсвийн хөрөнгөөр барилга байгууламж дансанд 28.0 сая төгрөгийн гадна төмөр хашаа, тоног төхөөрөмж дансанд 51.3 сая төгрөгийн үдийн цайны тоног төхөөрөмж, компьютер техник хэрэгсэл, Тавилга эд хогшилд 8.3 сая төгрөгөөр

ангийн ширээ сандал, насан туршийн боловсролын анги танхэмийг тохижуулах эд хогшлыг тус тус авсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үйл ажиллагааны нийт орлогын дүнд материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй орлого 122.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 21.9 сая төгрөгөөр буюу 1.16 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс буурсан материаллаг өөрчлөлт гарсан нь төвлөрүүлэх шилжүүлэг 89.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд хөрөнгийн ашиглах жил болон үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсанаар 0.1 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хуримтлагдсан үр дүнд өөрчлөлт орсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,832.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,832.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 128,6 сая төгрөгөөр бууруулж 1,703.9 сая төгрөгөөр баталсан байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар төсвийн орлогыг 1,703.9 сая төгрөгөөр зарлагыг 1,703.9 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн жилийн явцад 1 удаа тодотгол, 1 удаа зохицуулалт хийсэн байна.

Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 09 сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 97.2 сая төгрөгийн нэмэх тодотгол хийгдэж, энэ нь цалингийн зардалд 85,6 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 11,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Төсвийн зохицуулалт, тодотголыг аймгийн Засаг даргын 2021 оны А/608 тоот захирамжаар 24.7 сая төгрөгийн нэмэх тодотгол хийгдэж, үдийн цайны зардлаас 10.4 сая төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 52.8 сая төгрөгийг тус тус хасч, цалингийн зардалд 11.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1.5 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 2.0 сая төгрөг, шуудан холбоо интернэтийн төлбөрт 0.5 сая төгрөг, хог хаягдал хортон шавьж урсгалын зардалд 3.0 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл зардалд 13.0 сая төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэлд 3.0 сая төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл авах зардалд 1.0 сая төгрөг, багаж техник хэрэгсэлд 42.0 сая төгрөг, тавилга эд хогшилд 8.1 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 2.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 1.0 сая төгрөг, нэг удаагийн шагнал урамшуулалд 0.1 сая төгрөгийн зохицуулалтыг тус тус хийгдсэн байна. Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь нэмэх тодотголоор нийт 121.9 сая төгрөг нэмэгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,858.9 сая төгрөгийн төсөв баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,605.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 253.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,844.3 мянган төгрөгийг зарцуулж 14.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,844.3 сая төгрөг буюу 99,2 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0,6 сая төгрөгөөр, Хоолны зардлыг 9,0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 0,3 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 4,7 сая төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Сургуулийн хэмнэгдсэн зардлыг зарцуулах талаар Боловсролын сайдын 2021 оны 1а/6368 тоот албан бичиг, аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 401 тоот тушаалаар ерөнхий чиглэл өгсөн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 2 хөтөлбөр, 6 арга хэмжээнд 4.8 сая төгрөгөөр дутуу зарцуулагдаж, үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

71802 буюу Ерөнхий боловсрол хөтөлбөрийн хүрээнд 6 зориулалт арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

Зориулалт, арга хэмжээний код	Арга хэмжээний нэр	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,070.8	1,070.8	0.0	0
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	234.6	234.6	0.0	Төвлөрүүлсэн
80109	ТШЗ ийн байгууллагуудын тогтмол зардал	269.8	269.7	0.1	Төвлөрүүлсэн
81807	Дотуур байрны хүүхдийн хоол	166.3	166.1	0.2	
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	0.1	0.1	0.0	
81801	Үдийн цай	59.0	54.7	4.3	Төвлөрүүлсэн
Дүн		1,800.6	1,795.9	4.7	

71806 буюу Насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд 1 зориулалт арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

Зориулалт, арга хэмжээний код	Арга хэмжээний нэр	Төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Тайлбар
-------------------------------	--------------------	-------	-----------	-------	---------

81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	17.1	17.0	0.1	0
Дүн		17.1	17.0	0.1	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 21.6 сая төгрөг, тендерийн орлого 4.1 сая төгрөг, нийт 25.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2020 оны тайлант жилд түрээсийн номны орлогын зарцуулах эрх нээгдээгүйгээс авлагаар тусгасан 8.4 сая төгрөг орсон, аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 сарын 17-ны өдрийн А/40 тоот тушаалаар ариутгалын зардалд 0.6 сая төгрөг, 2021 оны 12 сарын 09-ны өдрийн А/54 тоот тушаалаар 0.6 сая төгрөг бичиг хэргийн зардалд, сумын Засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 10 сарын 26-ны өдрийн А/28 тоот тушаалаар 1.3 сая төгрөгийн ариутгал халдваргүйжилтийн зардалд, сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021 оны 11 сарын 03-ны өдрийн А/66 тоот тушаалаар боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд 10.6 сая төгрөг, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 0.1 сая төгрөг Хүрэхүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд, тендерийн орлого 4.1 сая төгрөг тус тус орж зарцуулагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг тус сургуулийн Захирлын 2021 оны 11 сарын 19-ны өдрийн А/72 тоот тушаалаар томилогдсон комисс хийж гүйцэтгэхдээ үндсэн хөрөнгө бүрд бар код нааж бүх үндсэн хөрөнгүүдийг хаягжуулсан ололттой ажлыг нэвтрүүлсэн байна.

Тайлант онд Ковид-19 цар тахлын улмаас сургуулийн үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим алдагдсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 4.7 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д зааснаар, хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болох www.shilendans.gov.mn -д ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгасан.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан боловч цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш нийт зарлагын гүйлгээг дутуу оруулсан зөрчилтэй байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 65 мэдээлэлээс хугацаандаа оруулсан 63 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Монгол Улсын Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай.” гэж, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800 (нэг мянга найман зуун) төгрөг байхаар тогтоож...” гэж тус тус заасныг мөрдөн ажилласан байна. Мөн Засгийн газрын “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (Гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай.” гэж заасныг дагаж мөрдөж байна.
- Тайлант хугацаанд “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж, "11.7" хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж, "11.5" хувь болж өөрчлөгдсөн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 төрлийн зөвлөмж хүргүүлсэнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар залруулсан 4 алдаа , 1 зөвлөмж өгч ажиллаа.

4.1 Залруулсан алдаа

4.1.1. Аудитын гүйцэтгэлийн шатанд Санхүүгийн тайланг иж бүрэн хийж ирүүлэн залруулав.

4.1.2. Аудитын гүйцэтгэлийн шатанд Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө залруулав.

4.1.3. Аудитын гүйцэтгэлийн шатанд хөрөнгийн тооллогоорх дүнг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт хүргүүлээгүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй Холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Шилэн дансанд байршуулсан мэдээллүүд нь хугацаандаа шивж оруулсан боловч мэдээний чанар, гүйцэтгэл муу байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтыг хэрэгжүүлэх. Иж бүрэн байх байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Авлагын данстай холбоотой.

2.1. **Илрүүлэлт:** Олон жил болсон 4.4 сая төгрөгийн авлагыг холбогдох нотлох баримтын дагуу данснаас хасч тайлагнаагүй. Төлилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. **Өгсөн зөвлөмж:** Авлагын эцсийн үлдэгдлээр тайлагнагдсан 4.4 сая төгрөгийн маргаантай авлагыг 2022 онд барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль	5	4.4	4	0.0	0	0	0	0	1	4.4

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС
ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

АХЛАХ АУДИТОР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС
ХЯНАСАН:

Чанарын менежер

БОЛОВСРУУЛСАН:
АУДИТОРЫН ТУСЛАХ

А.ЭРДЭНЭБААТАР

Огноо:

Э.БАТ-ЭРДЭНЭ

Огноо:

Б.ТЭГШДЭЛГЭР

Огноо:

Д.Гэрэлчулуун

Огноо:

Д.Балжинням

Огноо:

